



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

ТӨСВИЙН ТӨВЛӨРҮҮЛЭН ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2024/21/-НА-СТА-ТТЗ

ТӨВ АЙМГИЙН ӨНДӨРШИРЭЭТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН 2023
ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Зуунмод 2024 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn

Аудитор Г.Баянжаргал

Утас: 70273204 Цахим хаяг: bayanjargalg@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.open.audit.mn

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	4
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ .	6
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	11
3.5.2 Авлага.....	14
3.5.3 Урьдчилгаа.....	14
3.5.4 Бараа материал.....	14
3.5.5 Бусад эргэлтийн хөрөнгө.....	15
3.5.6 Үндсэн хөрөнгө.....	15
3.5.7 Өр төлбөр.....	16
3.5.10 Засгийн газрын хувь оролцоо	16
4. АУДИТЫН ТАЙЛАН	20
4.1 Ерөнхий зүйл	20
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	20
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	20
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	21
4.5.1 Завсрын аудитын талаар.....	21
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	21
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	22
5.1 Төлбөрийн акт	22
5.2 Албан шаардлага	22
5.3 Зөвлөмж	23
6. Санхүүгийн тайлангийн аудитад хамрагдсан байгууллагуудын санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл.....	24
7. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	24
7.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл	24
7.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл	24
7.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	25

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
СТСХ	Санхүү, төрийн сангийн хэлтэс
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ХХААГ	Хүнс хөдөө аж ахуйн газар
ХАА	Хөдөө аж ахуй
ОНХС	Орон нутгийн хөгжлийн газар
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ТӨВ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

41100, Төв аймаг, Зуунмод сум
Утас: 70272582. Цахим шуудан: tuv@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

додг 03.25 № 01/243
танай _____-ны № _____-т

ТӨВ АЙМГИЙН ӨНДӨРШИРЭЭТ
СУМЫН ЗАСАГ ДАРГА
А.ДАВАА-ОЧИР ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.3-д заасны дагуу Төв аймгийн Өндөрширээт сумын Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Төв аймгийн Өндөрширээт сумын Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Төв аймгийн Өндөрширээт сумын Засаг дарга нь аймгийн Засаг даргатай "Түүхт ой-бүтээн байгуулалт" урианы жилийн төлөвлөгөөг баталж, хэрэгжүүлэхээр байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөг 6 чиг үүргийн 20 зорилтын хүрээнд 108 арга хэмжээг хэрэгжүүлэхээр баталсан байна. Аймгийн Засаг даргын 2024 оны 02 дугаар сарын 19-ний өдрийн " Сумдын 2023 оны жилийн эцсийн үйл ажиллагааны үр дүнгийн тухай" А/104 тоот захирамжаар үр дүнтэй хэрэгжсэн 51 арга хэмжээ, тодорхой үр дүнд хүрсэн 44 арга хэмжээ, эрчимжүүлэх шаардлагатай 11 арга хэмжээ, хэрэгжээгүй 2 арга хэмжээтэй 86,54 хувиар биелүүлж, "В" үнэлгээтэй дүгнэгдсэн байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь аудиторын мэргэжлийн шийдлээр тайлант хугацааны санхүүгийн тайлангийн аудитад чухал нөлөө үзүүлсэн дараах асуудлууд байна.

Төв аймгийн Өндөрширээт сумын орон нутгийн орлогод 432,064.9 мянган төгрөг орж 112,9 хувиар биелсэн боловч 5 нэр төрлийн орлого 113,895.0 мянган төгрөгөөр тасарсан, улсын төсөвт төвлөрүүлэх орлогод 4,995.8 мянган төгрөг төвлөрүүлж 57,5 хувиар биелсэн бөгөөд, 1 нэр төрлийн орлого 2,005.1 мянган төгрөгөөр тасарсан байна.

G/Архив/Албан бичиг 2023/ А4

019020555

Бусад асуудлын хэсэг

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ. Тус санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2022оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН		958,104.50	1,102,349.10
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	3а, 3б	404,521.40	475,882.70
33	АВЛАГА	5а, 5б, 6а, 6б	404,604.40	414,846.00
35	БАРАА МАТЕРИАЛ	8а, 8б, 8в	148,978.70	211,620.50
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН		1,062,342.40	1,281,454.00
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	12а, 12б, 12в	1,062,342.40	1,281,454.00
39200	Биет хөрөнгө		1,045,209.70	1,264,623.90
39300	Биет бус хөрөнгө	13	17,132.70	16,830.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II		2,020,446.90	2,383,803.00
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР		1,000.00	1,227.10
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	15а, 15б	1,000.00	1,227.10
41300	Өглөг	17а, 17б	1,000.00	1,227.10
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН		2,019,446.90	2,382,576.00
51	Засгийн газрын хувь оролцоо		2,019,446.90	2,382,576.00
51100	Засгийн газрын оруулсан капитал		429,418.10	429,418.10
51200	Хуримтлагдсан үр дүн		1,392,517.20	1,755,646.20
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		197,511.70	197,511.70
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V		2,020,446.90	2,383,803.00

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Тодруу лга	2022оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)		5,147,911.4	2,205,584.4
11	ТАТВАРЫН ОРЛОГО		359,101.8	409,982.8
110	Орлогын албан татвар		143,347.8	160,706.4
1100	Хувь хүний орлогын албан татвар		149,006.9	167,706.4
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт		-5,659.1	-7,000.0
113	Хөрөнгийн албан татвар		127,911.0	121,509.6
118	Бусад татвар, төлбөр, хураамж		87,843.0	127,766.8
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1а, 1б	3,857,229.5	439,343.2
120	Нийтлэг татварын бус орлого		3,854,679.5	439,343.2
122	Тусламжийн орлого		2,550.0	0.0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		931,580.1	1,356,258.4
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2а, 2б	1,402,688.4	1,802,093.1
21	УРСГАЛ ЗАРДАЛ		1,149,223.4	1,348,379.2
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		1,125,531.0	1,289,681.2
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		288,590.9	448,769.8
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		35,882.2	55,764.5
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		360,927.0	31,818.8
2104	Хангамж, бараа материалын зардал		60,772.3	52,330.4
2105	Нормативт зардал		117,149.4	81,038.9
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		48,894.8	1,928.9
2107	Томилолт, зочны зардал		5,237.9	5,070.2
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		28,227.5	4,252.7
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		179,849.0	608,707.1
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		23,692.4	58,698.0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		253,464.9	453,713.9
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)		3,745,223.1	403,491.3
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН		0.0	0.0
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН		5,253,468.8	40,362.2
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)		1,508,245.8	363,129.0

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/ мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2022оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	1,512,724.60	1,939,225.90
11	ТАТВАРЫН ОРЛОГО	359,101.80	409,982.80
110	Орлогын албан татвар	143,347.80	160,706.40
1100	Хувь хүний орлогын албан татвар	149,006.90	167,706.40
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-5,659.10	-7,000.00
113	Хөрөнгийн албан татвар	127,911.00	121,509.60
118	Бусад татвар, төлбөр, хураамж	87,843.00	127,766.80
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	3,753.20	4,858.20
1181	Газрын төлбөр	5,645.10	5,229.60
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	78,444.60	117,679.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	222,042.60	172,984.80
120	Нийтлэг татварын бус орлого	222,042.60	172,984.80
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	931,580.10	1,356,258.40
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,023,833.20	1,217,510.80
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,023,833.20	1,217,510.80
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	999,932.40	1,156,702.80
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	288,590.90	448,998.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	35,882.20	55,509.40
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	360,927.00	31,818.80
2104	Хангамж, бараа материалын зардал	32,496.00	33,463.40
2105	Нормативт зардал	104,927.50	78,973.70
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	53,874.30	2,279.90
2107	Томилолт, зочны зардал	5,237.90	5,070.20
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	27,743.90	4,242.60
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	90,252.80	496,346.90
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	23,900.80	60,808.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	488,891.30	721,715.20
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	425,653.60	521,179.90
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	425,653.60	521,179.90
2200	Дотоод эх үүсвэрээр	425,653.60	521,179.90
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-425,653.60	-521,179.90
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	-40,384.00	-129,174.00
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	40,384.00	129,174.00
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	22,853.70	71,361.30
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	381,667.70	404,521.40
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	404,521.40	475,882.70

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	7,090,200.9	7,090,200.9
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-3,562,508.2	-3,562,508.2
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	3,527,692.7	3,527,692.7
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.0	0.0
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0.0	0.0
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.0	0.0
7	Өмчид гарсан өөрчилөлт	0.0	0.0
8	Зарласан ногдол ашиг	0.0	0.0
9	Тайлант үеийн үр дүн	1,508,245.8	1,508,245.8
10	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,019,446.9	2,019,446.9
11	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	2,019,446.9	2,019,446.9
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.0	0.0
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,019,446.9	2,019,446.9
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.0	0.0
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0.0	0.0
16	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.0	0.0
17	Өмчид гарсан өөрчилөлт	0.0	0.0
18	Зарласан ногдол ашиг	0.0	0.0
19	Тайлант үеийн үр дүн	363,129.0	363,129.0
20	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,382,576.0	2,382,576.0

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,067,985.6	1,700,604.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,111,020.8	1,054,250.1
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,029,406.3	999,064.6
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	424,858.9	417,202.8
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	53,107.4	51,593.8
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	476,445.2	468,054.1
2104	Хангамж, бараа материалын зардал	27,037.3	24,809.3
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	8,000.0	6,420.5
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	10,987.3	4,232.5
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	23,900.0	21,681.5
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	81,614.5	55,185.5
2132	Бусад урсгал шилжүүлэг	81,614.5	55,185.5
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	806,964.8	517,179.9
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	150,000.0	129,174.0
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,067,985.6	1,734,109.7
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	326,915.6	318,731.6
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,349,424.9	1,354,281.1
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	391,645.1	61,096.9
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.0	102,997.3
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.0	136,503.0

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	2022оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	45,267.8	90,416.6
21	УРСГАЛ ЗАРДАЛ	45,267.8	90,416.6
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	20,302.7	73,936.5
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	0	29,368.5
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	0	3,581.9
2104	Хангамж, бараа материалын зардал	4,335.7	7,282.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	15,673.0	33,704.1
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	24,965.1	16,480.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	5,153.2	0
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	19,811.9	16,480.0
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	45,059.3	90,416.6
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	45,059.3	90,416.6
III	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)= (I)-(II)	(208.5)	0
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	208.5	0
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0	0

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Төв аймгийн Өндөрширээт сумын Засаг дарга нь Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.1-д “Засаг дарга нь харьяалах нутаг дэвсгэртээ хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр, харьяалах дээд шатны Засаг даргын шийдвэрийн гүйцэтгэлийг хангах, түүнчлэн тухайн Хурлын шийдвэрийг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий төрийн төлөөлөгч мөн” гэж заасан ба мөн хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1-д “Сумын Засаг дарга харьяалах нутаг дэвсгэрийн хэмжээнд дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ” гэж заасны дагуу бүрэн эрхийг хэрэгжүүлдэг байна.

Мөн Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2-д “Төсвийн ерөнхийлөн захирагч төсвийн удирдлагын талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ” гэж заасны дагуу 14.2.1-14.2.12-т заасан бүрэн эрхийг, мөн хуулийн 15 дугаар зүйлийн 15.4-д “Төсвийн төвлөрүүлэн захирагч нь түүнд харьяалагдах төсвийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ” гэж заасан бүрэн эрхийг тус тус хэрэгжүүлэн, Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангаа аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчид нэгтгэн тайлагнадаг байна.

Төв аймгийн Өндөрширээт сумын Засаг дарга нь аймгийн Засаг даргатай “Түүхт ой бүтээн байгуулалтыг дэмжих жил” зорилтын хүрээнд байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөг 6 зорилтын хүрээнд 20 чиглэлийн 108 арга хэмжээг хэрэгжүүлэхээр баталсныг 86,54 хувьтай биелүүлж, “В” үнэлгээтэй дүгнэгдсэн байна.

Тайлант онд Өндөрширээт сумын Засаг дарга нь төлөвлөсөн ажлаа 100%-тай буюу бүрэн хэрэгжсэн 51 арга хэмжээ, 70%-90%-тай буюу тодорхой үр дүнд хүрсэн 44 арга хэмжээ, 30%-50%-тай буюу эрчимжүүлэх шаардлагатай 11 арга хэмжээ, хэрэгжээгүй 2 арга хэмжээтэйгээр хэрэгжүүлсэн байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Өндөрширээт сумын Засаг дарга нь үйл ажиллагаандаа Монгол Улсын Үндсэн хууль, Төрийн албаны тухай хууль, Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нийгмийн даатгалын тухай хууль, Хувь хүний орлогын албан татварын тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Шилэн дансны тухай хууль зэргийг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамрагдаагүй, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Өндөрширээт сумын 2023 оны санхүүгийн тайлангийн аудитаар нэгтгэсэн тайланд хамрагдаж байгаа байгууллагаас ЗДТГ “хязгаарлалттай” дүгнэлт авч, ИТХ, эргэлтийн эмийн сан, орон нутгийн хөгжлийн сан, хоршоо хөгжүүлэх сан, байгалийн нөхөн сэргээлтийн барьцаа сан нь түүвэрт хамрагдсан байна. Тусгай санхүүжилтийн 4 орон нутгийн байгууллагын байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг санхүүжүүлж, нэгтгэсэн тайланд тайлагнасан байна.

Төлөвлөлтийн үе шатанд дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзсэн.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ

илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Өндөрширээт сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Төв аймгийн Өндөрширээт сумын Засаг даргын нэгтгэсэн тайланд мөрдөх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг байхгүй байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Төв аймгийн Өндөрширээт сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 363,356.2 мянган төгрөгөөр буюу 18,0 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган

төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	404,521.4	475,882.7	71,361.3
Авлага	404,604.4	414,846.0	10,241.6
Бараа материал	148,978.7	211,620.5	62,641.8
Үндсэн хөрөнгө	1,062,342.4	1,281,453.9	219,111.5
Нийт хөрөнгө	2,020,446.9	2,383,803.1	363,356.2
Өр төлбөр	1,000.0	1,227.1	227.1
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	2,019,446.9	2,382,576.0	363,129.1
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	2,020,446.9	2,383,803.1	363,356.2

Дээрх хүснэгтээс харахад өмнөх оноос дараах байдлаар өөрчлөгдсөн байна. Үүнд:

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 475,882.7 мянган төгрөг болж, өмнөх оноос 71,361.3 мянган төгрөгөөр өссөн байна. Энэ нь Орон нутгийн ерөнхий орлогын дансны үлдэгдэл 291,059.3 мянган төгрөг болж, өмнөх оноос 33,271.5 мянган төгрөгөөр, эмийн эргэлтийн сангийн үлдэгдэл 47,320.4 мянган төгрөг болж, 4,584.1 мянган төгрөгөөр, Орон нутгийн хөгжлийн сангийн дансны үлдэгдэл 132,191.1 мянган төгрөг болж, 101,582.7 мянган төгрөгөөр өссөн, Хоршоо хөгжүүлэх сангийн үлдэгдэл 4,311.9 мянган төгрөг болж, 68,077.1 мянган төгрөгөөр буурсан нь нөлөөлсөн байна.

Авлага дансны үлдэгдэл 414,845.9 мянган төгрөг болж, өмнөх оноос 10,241.5 мянган төгрөгөөр өссөн нь Хоршоо хөгжүүлэх сангийн авлагын үлдэгдэл 296,798.1 мянган төгрөг болж, 73,994.4 мянган төгрөгөөр, эмийн эргэлтийн сангийн авлагын үлдэгдэл 28,952.8 мянган төгрөг болж, 2,812.2 мянган төгрөгөөр өссөн бөгөөд орон нутгийн хөгжлийн сангийн авлагын үлдэгдэл 89,050.0 мянган төгрөг болж, 66,565.0 мянган төгрөгөөр буурсан нь нөлөөлсөн байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 211,620.5 мянган төгрөг болж, өмнөх оноос 62,641.7 мянган төгрөгөөр өссөн нь ЗДТГ-ын бараа материалын дансны үлдэгдэл 174,808.5 мянган төгрөг болж, 66,956.1 мянган төгрөгөөр, ИТХ-ын бараа материалын дансны үлдэгдэл 3,269.9 мянган төгрөг болж, 363.0 мянган төгрөгөөр өссөн, эмийн эргэлтийн сангийн бараа материалын дансны үлдэгдэл 33,542.0 мянган төгрөг болж, 4,677.3 мянган төгрөгөөр буурсан нь нөлөөлсөн байна.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 1,281,453.9 мянган төгрөг болж, өмнөх оноос 219,111.5 мянган төгрөгөөр өссөн нь ЗДТГ-ын үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 1,270,772.3 мянган төгрөг болж, 216,696.0 мянган төгрөгөөр, эмийн эргэлтийн сангийн үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 10,269.1 мянган төгрөг болж, 2,745.5 мянган төгрөгөөр өссөн, ИТХ-ын үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 412.5 мянган төгрөг болж, 330.0 мянган төгрөгөөр буурсантай холбоотой байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 1,227.1 мянган төгрөг болж, өмнөх оноос 227.1 мянган төгрөгөөр өссөн нь эргэлтийн эмийн сангийн өглөг 227.1 мянган төгрөгөөр үүссэн нөлөөлсөн байна.

Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ 2,382,576.0 мянган төгрөг болж, өмнөх оноос 363,129.1 мянган төгрөгөөр өссөн нь тайлант оны үр дүн 363,356.2 мянган төгрөгөөр өссөнтэй холбоотой байна.

3.4.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 475,882.7 мянган төгрөг болж, өмнөх оноос 71,361.3 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 2. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Банканд байгаа бэлэн мөнгө	404,521.4	475,882.7	71,361.3
Төгрөг	404,521.4	475,882.7	71,361.3
Төрийн сангийн харилцах	361,785.1	428,562.3	66,777.2
Арилжааны банк дахь харилцах	42,736.3	47,320.4	4,584.1
Дүн	404,521.4	475,882.7	71,361.3

Эх сурвалж: Өндөрширээт сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн мөнгөн хөрөнгийн тодруулга

Мөнгөн хөрөнгийн Төрийн сангийн харилцах дансны 428,562.3 мянган төгрөгийн 67,9 хувь буюу 291,059.3 мянган төгрөгийг орон нутгийн төсвийн ерөнхий орлогын, 30,9 хувь буюу 132,191.1 мянган төгрөгийг Орон нутгийн хөгжлийн сангийн, 1,0 хувь буюу 4,311.9 мянган төгрөгийг хоршоо хөгжүүлэх сангийн, 0,2 хувь буюу 1,000.0 мянган төгрөгийг байгалийн нөхөн сэргээлтийн барьцаа сангийн дансны үлдэгдэл эзэлж байна. Эмийн эргэлтийн сангийн үлдэгдэл 47,320.4 мянган төгрөг арилжааны банканд байршиж байна.

Төрийн сангийн харилцах дансны үлдэгдэл 66,777.2 мянган төгрөгөөр өссөн нь Орон нутгийн төсвийн ерөнхий орлогын мөнгөн хөрөнгийн үлдэгдэл нь өмнөх оноос 33,271.5 мянган төгрөгөөр, Орон нутгийн хөгжлийн сангийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл өмнөх оноос 101,582.7 мянган төгрөгөөр өссөн болон хоршоо хөгжүүлэх сангийн мөнгөн хөрөнгийг үлдэгдэл нь өмнөх оноос 68,077.1 мянган төгрөгөөр буурсантай холбоотой байна.

Арилжааны банканд эмийн эргэлтийн сангийн оны эцсийн үлдэгдэл 47,320.4 мянган төгрөг болж, 4,584.1 мянган төгрөгөөр өссөн байна.

Аудитын илрүүлэлт:

- Сумын ЗДТГ, ИТХ-ын санхүүгийн тайланд Аймгийн Засаг даргын 2023 оны 01 дүгээр сарын 20-ны Б/02 тоот захирамжаар сумын Засаг даргад, сумын Засаг даргын 2023 оны 01 дүгээр сарын 27-ны Б/01 тоот захирамжаар Засаг даргын орлогч болон 4 багийн Засаг дарга нарт 10,463.2 мянган төгрөгийн, сумын ИТХ-ын даргын 2023 оны 01 дүгээр сарын 25-ны Б/01 захирамжаар өөртөө 2,525.3 мянган төгрөгийн, нийт 7 улс төрийн албан тушаалтанд 12,988.5 мянган төгрөгийн орон нутгийн нэмэгдэл цалин олгосон зөрчилд төлбөрийн акт тогтоож шийдвэрлэлээ.
- Хоршоо хөгжүүлэх сангийн үйл ажиллагааны зардлын 1,174.0 мянган төгрөгийг Эргэж төлөгдөх зээлээр буруу ангилан тайлагнасан зөрчилд зөвлөмж өгч, сангийн зарлагаар батлагдаагүй 708.0 мянган төгрөгийн албан томилолтын нөхөн олговор авсан зөрчилд төлбөрийн акт тогтоож шийдвэрлэлээ.

3.5.2 Авлага

Авлага дансны үлдэгдэл 414,845.9 мянган төгрөг болж, өмнөх оноос 10,241.5 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 3. Авлагын үлдэгдэл

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчидтай холбогдсон авлага	0	0	0
Байгууллагаас авах авлага	0	79,841.5	79,841.5
Хувь хүмүүсээс авах авлага	404,604.4	335,004.5	-69,599.9
Дүн	404,604.4	414,846.0	10,241.6

Эх сурвалж: Өндөрширээт сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн авлагын тодруулга

Авлага дансны жилийн эцсийн үлдэгдэл 414,846.0 мянган төгрөгийн 80,8 хувь буюу 335,004.5 мянган төгрөг нь Хувь хүмүүсээс авах авлага бөгөөд 19,2 хувь буюу 79,841.5 мянган төгрөг нь байгууллагаас авах авлага байна.

Авлага дансны үлдэгдэл 414,846.0 мянган төгрөгийн 21,5 хувь буюу 89,050.0 мянган төгрөгийг Орон нутгийн хөгжлийн сангийн, 71,5 хувь буюу 296,798.1 мянган төгрөгийг хоршоо хөгжүүлэх сангийн, 7,0 хувь буюу 28,952.8 мянган төгрөгийг эмийн эргэлтийн сангийн авлагын дансны үлдэгдэл эзэлж байна

Аудитын илрүүлэлт: Нэгтгэсэн санхүүгийн тайлангийн авлагын тодруулгад тайлант оны эцсийн үлдэгдлээс 89,095.0 мянган төгрөгийг тооцоо нийлсэн актаар баримтжуулаагүй байсныг залруулга хийлгэлээ .

3.5.3 Урьдчилгаа

Урьдчилгаа дансанд үлдэгдэлгүй байна.

3.5.4 Бараа материал

Бараа материалын дансны үлдэгдэл 211,620.5 мянган төгрөг болж, өмнөх оноос 62,641.7 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 5. Бараа материалын үлдэгдэл

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Түүхий эд материал	55,023.0	49,825.2	-5,197.8
Тусгай зориулалттай материал	16,803.7	16,283.2	-520.5
Эм боох материал	38,219.4	33,542.0	-4,677.3
Бэлэн бүтээгдэхүүн	1,946.0	10,725.0	8,779.0
Хангамжийн материал	59,949.7	68,850.3	8,900.6
Бичиг хэргийн материал	3,530.0	3,792.5	262.5
Аж ахуйн материал	21,658.3	28,298.5	6,640.2
Сэлбэг хэрэгсэл	21,095.0	21,095.0	0
Түлш, шатах тослох материал	357.3	655.2	297.9
Барилгын засварын материал	1,645.0	3,345.0	1,700.0
Бусад хангамжийн материал	11,664.1	11,664.1	0
Биологийн хөрөнгө	7,720.0	7,720.0	0.0
Мал амьтад	24,340.0	74,500.0	50,160.0
Дүн	148,978.8	211,620.5	62,641.7

Эх сурвалж: Өндөрширээт сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн бараа материалын тодруулга

Бараа материал дансны эцсийн үлдэгдэл 211,620.5 мянган төгрөгийн 82,6 хувийг ЗДТГ, 15,9 хувийг эмийн эргэлтийн сан, 1,5 хувийг ИТХ-ын бараа материал эзэлж байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 211,620.5 мянган төгрөг болж, өмнөх оноос 62,641.7 мянган төгрөгөөр өссөн нь ЗДТГ-ын бараа материалын дансны үлдэгдэл 174,808.5 мянган төгрөг болж, 66,956.1 мянган төгрөгөөр, ИТХ-ын бараа материалын дансны үлдэгдэл 3,269.9 мянган төгрөг болж, 363.0 мянган төгрөгөөр өссөн, эмийн эргэлтийн сангийн бараа материалын дансны үлдэгдэл 33,542.0 мянган төгрөг болж, 4,677.3 мянган төгрөгөөр буурсан нь нөлөөлсөн байна.

ЗДТГ-ын мал амьтад дансанд малын үнийг Тамгын газрын даргын 2023 оны 11 дүгээр сарын 29-ний А/43 тушаалаар шинэчлэн тогтоож, нас дэвшилтийн орлогоор 9,640.0 мянган төгрөгийн, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 46,000.0 мянган төгрөгийн 22 бярууг үнэ төлбөргүй хүлээн авсан нь нийт бараа материал дансны өөрчлөлтийн 80,0 хувийн нөлөөллийг үзүүлж байна.

Аудитын илрүүлэлт:

ИТХ-ын хуралдаанд зарцуулсан хоол хүнсний материалын зарцуулалт 1.650.5 мянган төгрөг нь тус байгууллагын бүтэн жилийн бараа материалын зарлагын 30.6 хувийг эзэлж байгаа зөрчилд зөвлөмж өгсөн байна.

3.5.5 Бусад эргэлтийн хөрөнгө

Бусад эргэлтийн хөрөнгө данс үлдэгдэлгүй байна.

3.5.6 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 1,281,453.9 мянган төгрөг болж, өмнөх оноос 219,111.5 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 7. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Биет хөрөнгө	1,045,209.7	1,045,209.7	219,414.2
Барилга, байгууламж, орон сууц	588,102.7	850,029.6	261,926.9
Авто-тээврийн хэрэгсэл	211,224.4	171,067.4	-40,157.0
Машин тоног төхөөрөмж(компьютер)	45,910.5	55,531.8	9,621.3
Тавилга, аж ахуйн эд хогшил	15,611.7	13,171.0	-2,440.7
Зам гүүрний байгууламж	80,113.3	77,877.4	-2,235.9
Бусад үндсэн хөрөнгө	104,247.1	96,946.8	-7,300.4
Биет бус хөрөнгө	17,132.7	16,830.0	-302.7
Программ хангамж	1,120.7	818.0	-302.7
Бусад биет бус хөрөнгө	16,012.0	16,012.0	0
Дүн	1,062,342.4	1,281,453.9	219,111.5

Эх сурвалж: Өндөрширээт сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үндсэн хөрөнгийн тодруулга

Үндсэн хөрөнгө дансны жилийн эцсийн хөрөнгийн үлдэгдлийн 99,2 хувь буюу 1,270,772.3 мянган төгрөгийг сумын ЗДТГ, 0,03 хувь буюу 412.5 мянган төгрөгийг ИТХ, 0,77 хувь буюу 10,269.1 мянган төгрөгийг эмийн эргэлтийн сангийн хөрөнгө эзэлж байна.

Үндсэн хөрөнгийн элэгдэл хорогдлын зардал 124,688.9 мянган төгрөг байна.

Аудитын илрүүлэлт:

- Өндөрширээт сумын ЗДТГ-ын эзэмшилд байгаа газрыг данс бүртгэлд бүрэн аваагүй, байгууллагын 6 тээврийн хэрэгсэлд ялгагдах тод дэвсгэр өнгө бүхий улсын дугаар аваагүй зөрчилд зөвлөмж өгч, Шинэ суурьшлын бүсэд эрчим хүч татах, дэд бүтэц бий болгосон 154,000.0 мянган төгрөгийн хөрөнгийг орлогод авч тайлагнаагүй зөрчилд албан шаардлага хүргүүлж шийдвэрлэлээ.
- Сумын ИТХ нь нийт 5.293.3 мянган төгрөгийн 13 ширхэг үндсэн хөрөнгөөс 412.5 мянган төгрөгийн үлдэгдэл өртөгтэй 1 хөрөнгөөс бусад 12 хөрөнгө нь үлдэгдэл өртөггүй байна. Журмын дагуу үнэлгээ хийж шийдвэрлэх зөвлөмж өгөгдлөө.

3.5.7 Өр төлбөр

Нийт өр төлбөр дансны үлдэгдэл 1,227.1 мянган төгрөг болж, өмнөх оноос 227.1 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 8. Нийт өр төлбөрийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажилчидтай холбогдсон өглөг	0	0	0
Хувь хүмүүст төлөх өглөг	0	24.3	24.3
Байгууллагад төлөх өр	1,000.0	1,202.8	202.8
Дүн	1,000.0	1,227.1	227.1

/ мянган төгрөгөөр/
Эх сурвалж: Өндөрширээт сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн өглөгийн тодруулга

Өр төлбөр дансны эцсийн үлдэгдэл 1,227.1 мянган төгрөгийн 81,5 хувь буюу 1,000.0 мянган төгрөг нь байгалийн нөхөн сэргээлтийн барьцаа сангийн үлдэгдэл, 18,5 хувь буюу 227.1 мянган төгрөг нь эмийн эргэлтийн сангийн үлдэгдэл байна.

Аудитын илрүүлэлт: Нэгтгэсэн санхүүгийн тайлангийн өглөгийн тодруулгад тайлант оны эцсийн үлдэгдлээс эмийн эргэлтийн сангийн 227.1 мянган төгрөгийг тооцоо нийлсэн актаар баримтжуулаагүй байсныг залруулга хийлгэлээ .

3.5.10 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ 2,382,576.0 мянган төгрөг болж, өмнөх оноос 363,129.1 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 9. Засгийн газрын хувь оролцоо

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	429,418.1	429,418.1	0
Хуримтлагдсан үр дүн	1,392,517.1	1,755,646.2	363,129.1
Өмнөх үеийн үр дүн	2,900,762.1	1,392,517.1	-1,508,245.0
Тайлант үеийн үр дүн	-1,508,245.0	363,129.0	1,871,374.0
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	197,511.7	197,511.7	0
Дүн	2,019,446.9	2,382,576.0	363,129.1

/ мянган төгрөгөөр/
Эх сурвалж: Өндөрширээт сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ 2,382,576.0 мянган төгрөг болж, өмнөх оноос 363,129.1 мянган төгрөгөөр өссөн нь өглөгийн дансны 227.1 мянган төгрөгөөр өссөн, тайлант оны үр дүн 363,356.2 мянган төгрөгөөр өссөнтэй холбоотой байна.

Аудитын илрүүлэлт: Өмнөх оны аудитлагдсан нэгтгэсэн санхүүгийн тайлангийн өмчийн өөрчлөлтийн тайлан, үр дүнгийн тайланд тайлант үеийн үр дүнг засварлаж 10,739.2 мянган төгрөгөөр өөрчилсөн байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Төв аймгийн Өндөрширээт сумын төсвийн байгууллагуудын төсвийн төсөл саналыг нэгтгэн боловсруулсан мэдээлэл олдоогүй бөгөөд Өндөрширээт сумын ИТХ-ын 2022 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 05 дугаар тогтоолоор сумын орон нутгийн төсөвт төвлөрүүлэх татварын орлогыг 377,374.1 мянган төгрөг, татварын бус орлогыг 2,200.0 мянган төгрөг, татварын буцаалтыг 7,000.0 мянган төгрөг, нийт татварын орлогыг 379,574.1 мянган төгрөгөөр, 2022 оны төсвийн жилд зарцуулах урсгал зардлыг 1,952,174.5 мянган төгрөгөөр, орон нутгийн хөгжлийн сангийн зарлагыг 599,194.6 мянган төгрөгөөр, сум хөгжүүлэх сангийн зарлагыг 150,000.0 мянган төгрөгөөр баталсан байна.

Сумын ИТХ-ын 2023 оны 8 дугаар сарын 14-ний өдрийн 02 дугаар тогтоолоор сумын төсөвт төвлөрүүлэх нийт орлогыг 382,712.4 мянган төгрөгөөр, 2023 оны төсвийн жилд зарцуулах нийт зарлагыг 2,067,986.7 мянган төгрөгөөр тодотгож баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны төсвийг тодотголоор орон нутгийн төсөвт төвлөрүүлэх татварын орлогыг 378,271.5 мянган төгрөг, татварын бус орлогыг 4,440.9 мянган төгрөг, татварын буцаалтыг 7,000.0 мянган төгрөг, нийт татварын орлогыг 382,712.4 мянган төгрөгөөр, 2023 оны төсвийн жилд зарцуулах нийт зардлыг 2,067,986.7 мянган төгрөгөөр, орон нутгийн хөгжлийн сангийн зарлагыг 666,510.0 мянган төгрөгөөр, сум хөгжүүлэх сангийн зарлагыг 150,000.0 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 2,067,986.7 мянган төгрөгөөр ИТХ-ын 2023 оны 8 дугаар сарын 14-ний өдрийн “Сумын 2023 оны төсөв тодотгон батлах тухай” 02 дугаар тогтоолоор тодотгон баталсан байна.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 1,734,109.7 мянган төгрөгийн санхүүжилт олгож, орон нутгийн төсөвт 68,077.0 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,700,604.0 мянган төгрөг буюу 82,2 хувьтай байгаа нь үйл ажиллагааны зардлын төсвийг 367,381.6 мянган төгрөгөөр дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 10. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	ИТХ-ын үйл ажиллагаа	81,585.2	76,615.7	-4,969.5	96.8%
2	ЗДТГ-ын үйл ажиллагаа	722,492.4	667,289.6	-55,202.8	92.4%
3	Соёл урлагийн үйлчилгээ	104,563.6	101,249.1	-3,314.5	96.8%
4	ЭМТ-ийн үйлчилгээ	72,399.0	72,175.2	-223,8	99.7%
5	ЕБС-үйлчилгээ	248,156.4	247,712.7	-443,6	99.8%
6	Сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээ	22,279.0	19,238.8	-3,040.2	86.4%
7	Орон нутгийн хөгжлийн сан	666,510.0	387,148.9	-279,361.1	58.1%
8	Хоршоо хөгжүүлэх сан	150,000.0	129,174.0	-20,826.0	86.4%
	Сумын дүн	2,067,985.6	1,700,604.0	-367,381.6	82.2%

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Өндөрширээт сумын ЗДТГ, ИТХ-ын нэмэлт санхүүжилтийн дансанд дээд шатны төсөв захирагчаас 55,018.3 мянган төгрөг, төсөвт байгууллагын өөрийн орлого 35,398.3 мянган төгрөг, нийт 90,416.6 мянган төгрөгийн орлого тайлагнасан байна.

Нэмэлт санхүүжилтийн данснаас төрийн албан хаагчдын орон нутагт ажилласны нэмэгдэл цалин, нийгмийн даатгалын зардалд 32,950.4 мянган төгрөг, бусад бараа үйлчилгээний урсгал зардалд 40,986.1 мянган төгрөг, урсгал шилжүүлэгт 16,480.0 мянган төгрөг, нийт 90,416.6 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Нэмэлт санхүүжилтийн харилцах дансаар сумын Засаг даргын тамгын газар 84,047.1 мянган төгрөг, иргэдийн Төлөөлөгчдийн Хурал 6,369.5 мянган төгрөг зарцуулсан байна.

Зарцуулаагүй үлдэгдэл ЗДТГ-ын 15,886.4 мянган төгрөг, ИТХ-ын 593.7 мянган төгрөг, нийт 16,480.1 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тус төсөл хөтөлбөр хэрэгжих хугацаанд нийт 9 хөтөлбөрийн 22 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

Хүснэгт 11. Төсөл хөтөлбөрийн арга хэмжээний хүрэх үр дүн, биелэлт

№	Хөтөлбөр	Хэрэгжих хугацаа	Хүрэх үр дүн	Хэрэгжилтийн явц	/мянган төгрөгөөр/	
					Зарцуулах төсөв	Зарцуулсан
1	70105-Орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын үйл ажиллагаа	2023.01.01-2023.12.31	Төлөвлөгөөний хэрэгжилтээр	Нутгийн иргэдийнхээ хууль ёсны эрх ашгийг илэрхийлэх, төлөөлөх, Хэрэгжилт 100 %	81,585.2	76,615.7
2	70106- Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага	2023.01.01-2023.12.31	Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлагыг хэрэгжүүлэх	Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага хөтөлбөр 92.8 %	710,992.4	659,607.6
3	71411- Хүрээлэн буй орчны бодлого, удирдлага	2023.01.01-2023.12.31	Хүрээлэн буй орчны бодлого, удирдлагыг хэрэгжүүлнэ.	Хүрээлэн буй орчны бодлого, удирдлага хөтөлбөр 66.8 %	11,500.0	7,682.0
4	Соёл урлагийн үйлчилгээ	2023.01.01-2023.12.31	Дулаан, цахилгаанаар бүрэн хангах	Орон нутгийн тусгай шилжүүлгийн байгууллагын байр ашиглалтын тогтмол зардал Хэрэгжилт 100 %	104,563.6	101,249.1
5	Ерөнхий боловсролын үйлчилгээ	2023.01.01-2023.12.31	Дулаан, цахилгаанаар бүрэн хангах	Орон нутгийн тусгай шилжүүлгийн байгууллагын байр ашиглалтын тогтмол зардал Хэрэгжилт 100 %	248,156.4	247,712.7
6	Сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээ	2023.01.01-2023.12.31	Дулаан, цахилгаанаар бүрэн хангах	Орон нутгийн тусгай шилжүүлгийн байгууллагын байр ашиглалтын тогтмол зардал Хэрэгжилт 100 %	22,279.0	19,238.8
7	ЭМТ-ийн үйлчилгээ	2023.01.01-2023.12.31	Дулаан, цахилгаанаар бүрэн хангах	Орон нутгийн тусгай шилжүүлгийн байгууллагын байр ашиглалтын тогтмол зардал Хэрэгжилт 100 %	72,399.0	72,175.2

8	Орон нутгийн хөгжлийн сан	2023.01.01-2023.12.31	хөрөнгө оруулалт төсөл арга хэмжээ	Орон нутгийн тусгай шилжүүлгийн байгууллагын байр ашиглалтын тогтмол зардал Хэрэгжилт 100 %	666,510.0	387,148.9
9	70106-Хоршоо хөгжүүлэх сан	2023.01.01-2023.12.31	Эргэж төлөгдөх зээл олголтын үйлчилгээ	Орон нутгийн тусгай шилжүүлгийн байгууллагын байр ашиглалтын тогтмол зардал Хэрэгжилт 100 %	150,000.0	129,174.0

Төв аймгийн Өндөрширээт сумын Засаг даргын Тамгын газар нь Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага /70106/ хөтөлбөр 92,8 хувиар, Хүрээлэн буй орчны бодлого, удирдлага /71411/ хөтөлбөр 66,8 хувиар хэрэгжсэн нь 2023 оны төсвийн жилд Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэн ажилласантай холбоотойгоор хэмнэгдсэн 55,202.8 мянган төгрөгийг татан төвлөрүүлсэн байна.

Хүрээлэн буй орчны бодлого, удирдлага хөтөлбөрийн хур хог хаягдал, орчны бохирдол арга хэмжээ 9,0 хувьтай хангалтгүй хэрэгжсэн байна.

3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Төв аймгийн Өндөрширээт сумын Засаг дарга нь тайлант онд худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний дагуу нээлттэй 2 тендер, онцгой журмаар 9 тендерийг зарлаж, нэгдсэн хогийн цэгийг лансфиллийн аргаар булаах, эрүүл мэндийн төвд суудлын автомашин авах, ахуйн үйлчилгээний байрны гадна фасад, дээврийн засвар болон сантехникийн засвар сайжруулалтын ажил, уурын зуухны гадна фасадыг засварлаж өвс тэжээлийн фонд болгох зэрэг бүтээн байгуулалтын ажлуудыг гүйцэтгэсэн байна.

Ерөнхий гэрээгээр худалдан авалт хийгдээгүй байна. Энэ нь цахим дэлгүүрт бүртгэгдсэн бараа, ажил үйлчилгээний сонголт бага, өртөг зардал өндөр байгаа тул өмч хамгаалах байнгын зөвлөлийн хурлаар шийдвэрлэж, шууд худалдан авалт хийж гэрээ байгуулан ажилласан байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Төв аймгийн Өндөрширээт сумын Засаг даргын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Г.Баянжаргал гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Өндөрширээт сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт сумын Засаг даргын 2024 оны 3 дугаар сарын 05-ны өдрийн 01/38 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр Төв аймгийн Өндөрширээт сумын Засаг даргын 2023 оны төсвийн гүйцэтгэлийн тайлангийн батлагдсан төсвийг, суурь үзүүлэлтээр нийт зарлага 2,067,986.7 мянган төгрөгийг сонгосон.

Материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг "дунд" гэж үнэлж, материаллаг байдлын түвшнийг 1,5 хувиар тогтоож, сонгосон суурь үзүүлэлтээс тооцож төлөвлөлтийн материаллаг байдлыг 31,019.8 мянган төгрөгөөр тогтоож баримтжууллаа.

Ажлын баримтад материаллаг байдлын суурь үзүүлэлт, хувь хэмжээг сонгосон шалтгаан, тайлбар болон материаллаг байдлыг шинж чанарын хувьд авч үзэх шалтгаан, тайлбарыг тусгасан болно.

Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн түвшинд гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 23,264.9 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийг мөрдөж ажилласнаар төсвийн жилийн хүрээнд Өндөрширээт сумын ЗДТГ нь тайлант онд Төрийн хэмнэлтийн тухай хуулиар хориглосон зардлууд гараагүй, өглөг үүсгээгүй, төсвийн хөрөнгийг хэмнэлттэй зарцуулан хуулийг хэрэгжүүлэн ажилласантай холбоотойгоор 2 хөтөлбөрийн 8 арга хэмжээнээс хэмнэгдсэн 55,202.8 мянган төгрөгийн зардлыг татан төвлөрүүлсэн байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг

стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Төв аймгийн Өндөрширээт сумын Засаг даргын шилэн дансны цахим хуудсанд тайлант онд байршуулбал зохих 169 мэдээллээс 2 мэдээллийн хугацаа болоогүй бөгөөд байршуулбал зохих 167 мэдээллээс 8 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн, 2 мэдээллийг (Орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөгөө, гүйцэтгэл, Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн хөтөлбөр, түүний хүрэх үр дүнгийн талаарх тоон болон чанарын үзүүлэлтийн төлөвлөгөө) байршуулаагүй, 89.8 хувийн хэрэгжилттэй байна.

Санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийсэн нийцлийн аудитаар илэрсэн зөрчлийг байгууллага тус бүрээр энэ тайлангийн санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл 7.3-д харуулав.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тус байгууллагад бусад хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэх алдаа, зөрчилтэй асуудал гараагүй байна.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Төв аймгийн Өндөрширээт сумын Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайланд завсрын аудит хийгдээгүй байна.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Тус байгууллага нь 2022 оны санхүүгийн тайлангийн аудитаар 1 төлбөрийн акт тогтоож, 1 зөвлөмж өгөгдсөнийг хэрэгжүүлж 2023 оны 6 дугаар сарын 22-ны 01/98 тоот албан бичгээр ирүүлж, fas.audit.mn системд бүрэн хэрэгжсэнээр шивсэн байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	7,000.5	1	7,000.5	100
Албан шаардлага	0	0	0	0	
Зөвлөмж	1	67,278.8	1	67,278.8	100
Нийт дүн	2	74,279.3	2	74,279.3	100

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Төв аймгийн Өндөрширээт сумын Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайланд дараагийн гүйцэтгэлийн аудитаар анхаарал хандуулах асуудлыг тодорхойлж байна. Үүнд:

- ОНХС-г төлөвлөх, батлах, санхүүжүүлэх, хэрэгжүүлэх, бүртгэх, тайлагнах, хяналт тавих үйл ажиллагаа, сумын иргэдийн санал авсан байдал, тендер шалгаруулалт, зарцуулалттай холбоотой асуудлыг үзнэ.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Залруулсан алдаа

Аудитаар нэгтгэсэн тайлангийн авлага, өглөгийн дансны тодруулгад 100,061.3 мянган төгрөгийн тооцоо нийлсэн байдал, өглөг, авлагын насжилттай холбоотой 2 алдаа¹ илэрснийг аудитын явцад залрууллаа.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-д “жинхэнэ хэрэгжилтийн”, 5.1.4-д “үнэн зөв байх” зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлнө, 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2-д “төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх” гэсэн заалттай нийцэхгүйгээс гадна санхүүгийн тайлангийн “иж бүрэн байх”, “толилуулга”, “үнэлгээ ба хуваарилалт” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн заалтын дагуу аудитын явцад залрууллаа.

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэлийг харьяа байгууллага тус бүрээр энэ тайлангийн 7.1-д харуулав.

Аудитаар 125,750.1 мянган төгрөгийн 2 зөрчил² илэрсний 9,850.0 мянган төгрөгийн 1 зөрчилд албан шаардлага тогтоож, 115,900.1 мянган төгрөгийн 1 зөрчилд зөвлөмж өглөө.

5.1 Төлбөрийн акт

Санхүүгийн нэгтгэсэн тайланд төлбөрийн акт тогтоогдсон зөрчил байхгүй байна.

Төлбөрийн акт тогтоогдсон зөрчлийг харьяа байгууллага тус бүрээр энэ тайлангийн санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл 7.2-д харуулав.

5.2 Албан шаардлага

Төв аймгийн ИТХ-ын 2017 оны 4 дүгээр сарын 26-ны 53 дугаар тогтоолоор 3 тээврийн хэрэгсэл, эсгийний цех, 2017 оны 12 дугаар сарын 21-ний 140 дугаар тогтоолоор агропарк худалдан борлуулж, нийт 9,850.0 мянган төгрөгийн орлогыг төсөвт төвлөрүүлээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1-д “хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх” гэсэн заалт болон санхүүгийн тайлангийн аудитын “толилуулга”, “эрх ба үүрэг”, “нийцсэн бөгөөд зохистой байх” зэрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө” заалт болон МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.11-д “хууль тогтоомж, гэрээ хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” үүсэн бол албан шаардлага өгөх гэсний дагуу шийдвэрлэв.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Албан шаардлага өгөгдсөн зөрчлийг харьяа байгууллага тус бүрээр энэ тайлангийн санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл 7.2-д харуулав.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал

1.1.Илрүүлэлт:

Тус сум тайлант онд орон нутгийн орлого нийт дүнгээр 432.064.9 мянган төгрөг орж 112,9 хувиар биелсэн боловч 5 нэр төрлийн орлого (Суутган-2, малын тоо толгойн албан татвар, галт зэвсгийн албан татвар, үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар, хөрөнгийн орлогын албан татвар) 113.895.0 мянган төгрөгөөр тасарсан, улсын төсөвт төвлөрүүлэх орлогод 4.995.8 мянган төгрөг төвлөрүүлж 57.5 хувиар биелсэн бөгөөд, 1 нэр төрлийн орлого (аж ахуйн нэгжийн орлогын албан татвар) 2.005.1 мянган төгрөгөөр тасарсан зөрчил байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.1-д "Батлагдсан төсвийг хэрэгжүүлэх нарийвчилсан хуваарь, төсвийн дэлгэрэнгүй хуваарилалт, төсвийн зарцуулалт болон бүрдүүлэлтэд тавих хяналтыг төсвийн сар, улирлын батлагдсан хуваарийн дагуу хэрэгжүүлнэ", 41.2.1-д "хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх" гэсэн заалт болон санхүүгийн тайлангийн аудитын "иж бүрэн байх", "нийцсэн бөгөөд зохистой байх" зэрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

1.2.Өгсөн зөвлөмж: Бүх шатны төсвийн орлогын төлөвлөгөөг нэр төрлөөр биелүүлэх.

Дээрх зөвлөмжийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д " Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ." заалтын дагуу хүргүүлж, биелэлтийг 2024 оны 6 дугаар сарын 14-ний өдрийн дотор Төв аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. Санхүүгийн тайлангийн аудитад хамрагдсан байгууллагуудын санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	Засаг дарга	1	1			1			
2	Засаг даргын тамгын газар	1	1				1		
3	Байгалийн нөхөн сэргээлтийн барьцаа сан	1		1					
4	Иргэдийн төлөөлөгчдийн хурал	1		1					
5	Орон нутгийн хөгжлийн сан	1		1					
6	Хоршоо хөгжүүлэх сан	1		1					
7	Эмийн эргэлтийн сан	1		1					
НИЙТ		7	2	5		1	1		

7. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

7.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/ мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
ЗД	2	100,061.3			2	100,061.3	2	100,061.3				
ЗДТГ	1	72,789.2	1	72,789.2			1	72,789.2				
ИТХ												
Дүн	3	172,850.5	1	72,789.2	2	100,061.3	3	162,111.3	0	0	0	0

7.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Засаг дарга	2	125,750.1			1	9,850.0	1	115,900.1				
ЗДТГ	5	217,704.1	1	10,463.2	1	154,000.0	3	53,240.9				
ИТХ	3	4,175.3	1	2,525.3			2	1,650.0				
ХХС	2	1,882.0	1	708.0			1	1,174.0				

Дүн	12	349,511.5	3	13,696.5	2	163,850.0	7	171,965.0			
-----	----	-----------	---	----------	---	-----------	---	-----------	--	--	--

7.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
ОНХС	1	938,529.1					1	938,529.1
Дүн	1	938,529.1					1	938,529.1
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн								
Нийт дүн								
Дүн								
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн								
Нийт дүн	1	938,529.1					1	938,529.1